



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А102

Бор-Өндөр

Ёс зүйн дэд хороог байгуулах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 13.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зөрчлийн талаарх ажлын тайлан мэдээ, судалгааг гаргах үүрэг бүхий Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Гишүүд:

Д.Мөнгөнтуяа

Бумбат 3 дугаар багийн Засаг дарга

Ц.Мөнхгэрэл

Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хоршооны суудал хариуцсан мэргэжилтэн

А.Өлзийсүрэн

Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

З.УУГАНЖАРГАЛ

